

**ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019 оны 06 сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Хуралд 4 гишүүн оролцсон (ирц 80%), Хурал ЭМЯ-ны Шуурхай Удирдлагын Газрын 306 тоот өрөөнд 12.30-14.10 цагт болов.

1. Б.Мягмар, ҮЗЗ-ийн дарга,
2. П.Анузаяа, ДЭМБ-ын мэргэжилтэн
3. Ж.Одгарьд, Гандан Тэгчинлэн хийд
4. Ц.Пүрэвжав, Олон нийтийн төлөөлөл

Урилгаар оролцсон гишүүн:

1. Т.Энхзаяа, НЭМГ-ын дарга
2. М.Сэргэлэн, ХЗН-ийн мэргэжилтэн
3. Индермохан Нарула, СОНА-ын багийн ахлагч
4. Т.Айра, СОНА
5. Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч
6. Л.Номин-Эрдэнэ, ҮЗЗ-ийн ажлын албаны ажилтан

ҮЗЗ-ийн гишүүд Гүйцэтгэх Хорооны хурлын хөтөлбөрийг санал нэгтгэйгээр хэлэлцэн баталж, Гүйцэтгэх Хорооны хурлыг ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар даргалав.

Хөтөлбөр 1. Хурлын хөтөлбөрийг батлах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийн талаар танилцуулах (сүрьеэгийн төсөлд нэмэлт 1,5 сая ам.доллар олгох тухай) М.Сэргэлэн, ХЗН-ийн мэргэжилтэн танилцуулав.

Төсөл эхэлсэн байдал: Глобаль сан нь манай улсад хэрэгжиж байгаа сүрьеэгийн төсөлд нэмэлт санхүүжилт олгох тухай мэдэгдлийг Үндэсний зохицуулах зөвлөлд 2018 оны 10-р сарын 30-нд мэдэгдсэн байна.

Глобаль сангийн санхүүжилтээр эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатанд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сүрьеэгийн илрүүлэг, оношлогоо, эмчилгээний сургалтын багц боловсруулах, сүрьеэ болон вируст гепатитаас урьдчилан сэргийлэх талаар иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэхэд зарцуулахаар болсон байна.

Энэхүү үзэл баримтлалыг ЭМЯ-нд танилцуулж АХБ болон ДЭМБ зэрэг бусад түншүүдтэй тохиролцож 2018 оны 10-р сарын 31-нд Монголын Глобаль сангийн ҮЗЗ-с төслийг өргөн барьж дэмжигдсэн хариуг 2019 оны 1-р сарын 8-нд хүлээн авсан байна.

Төсөл батлагдсан байдал: 2019 оны 02 сарын 18-22-ны хооронд Глобаль сангийн Монгол Улсын асуудал хариуцсан менежер Аллан Нфамба ирж ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадорж, НЭМГ-ын дарга Т.Энхзаяа нартай уулзсны дараа АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын ахлах мэргэжилтэн

Ж.Алтантуяатай уулзаж нэмэлтээр олгох 1.5 сая ам.долларын төслийн хэрэгжилтийн талаар ярилцсан.

Үүний дагуу Глобаль сангийн ЭМЯ-ны Глобаль сангийн хөтөлбөр зохицуулах нэгж Сүрьеэгийн төслийн нэмэлт 500 000 ам.долларыг Азийн хөгжлийн банкны “Вируст гепатитын урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, эмчилгээг сайжруулах” төсөлтэй хамтран хэрэгжүүлэх үндсэн бичиг баримтыг боловсруулж 2019 оны 02 сарын 27-ны өдөр өргөн барьсан. Төсөлд АХБ-ны 800 000 ам доллараас 200 000 ам долларыг сүрьеэгийн төсөлд авч зарцуулахаар туссан. Энэ нь ЭМЯ-наас суурин рентген энэхүү төслөөс авах хүсэлт гаргасантай холбоотой.

Өргөн барьсан төсөл нь 2019 оны 05 сарын 22-ны өдөр Глобаль сангийн Удирдах зөвлөлөөс баталсан. Баталсан гэрээний төслийг зурж ирүүлснийг ЭМСайд баталгаажуулсан.

Цаашид хийх үйл ажиллагаа

1. АХБ-ны Гепатитын төслийн 800 000 ам долларын зарцуулалтад зарим нэмэлт өөрчлөлт оруулах, хугацааг 2020 оны 12 сар хүртэл сунгах хүсэлтийг ЭМЯ-наас АХБ-нд хүргүүлэх. Учир нь уг төсөл ЭМЯ-ны ЭТГ-ын удирдлага дор хэрэгжиж байгаа юм.
2. Уг захидлын дараа АХБ-ны Гепатитын төслийн зарим үйл ажиллагаанд өөрчлөлт орсон, Глобаль сантай хамтран үйл ажиллагааг үргэлжлүүлэх болсонтой холбоотой ЭМЯ, АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Глобаль сангийн Хөтөлбөр зохицуулах нэгж нь гурвалсан гэрээ байгуулна.
3. Үүний дараа үйл ажиллагааг эхлүүлнэ. Өнөөгийн үүссэн нөхцөл байдалтай уялдуулан уг төслийг яаралтай эхлүүлж иргэд, олон нийтийн мэдээлэл, сургалт, сурталчилгаанд зарцуулагдах 203 000 ам долларыг ЭМЯ-наас чиглүүлэн ашиглах шаардлагатай байна. Үүнээс гадна 200 000 ам долларын рентген аппаратын үзүүлэлтийг гаргаж захиалгыг яаралтай хийх хэрэгтэй байна.
4. Төслийг ЭМЯ-ны АХБ-ны элэг бүтэн Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ЭТГ удирдан зохион байгуулна
5. АХБ-ны хөнгөлттэй зээл болох 160 сая ам доллар батлагдсны дараа Глобаль сангийн 1 сая ам долларыг Монголын Засгийн газарт өгөхөөр тохирсон байгаа.

Б.Оюундарь: Таны дээр дурдсан 200 000 ам долларын рентген аппаратыг хаана, ямар аймгуудад хуваарилахаар төлөвлөж байна вэ?

М.Сэргэлэн: Одоогоор яг энэ талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаагүй байна. Ямартай ч аппаратаа авах хэрэгтэй гэсэн санал гарсан байна.

П.Анузаяа: Энэ 200 000 ам долларын рентген аппарат Сүрьеэгийн төслийн нэмэлт 500.000 ам.доллартаа багатаж байгааа юу? Эсвэл тусдаа тоног төхөөрөмжийн санхүүжилтээр орж ирэх үү?

М.Сэргэлэн: Сүрьеэгийн төслийн нэмэлт 500

000 ам.долларын санхүүжилтын 200 000 ам доллар нь тоног төхөөрөмжийн санхүүжилтэнд, 300 000 ам доллар нь үйл ажиллагааны санхүүжилтэнд хуваарилагдана.

Хөтөлбөр 2. Сүрьеэгийн чиглэлээр цаг үеийн мэдээлэл хийх, Т.Энхзаяа, ЭМЯ-ны НЭМГ-ын дарга

Энэ асуудлын хүрээнд ЕБС-д хийгдэж байгаа сүрьеэгийн оношлогоо эмчилгээний талаар танилцуулах болно. Сүүлийн үед Сүрьеэгийн тархалтын талаарх мэдээлэл их байгаатай холбогдуулан ЗГ-ын 2 ч удаагийн хурлаар энэ талаар хэлэлцсэн. Энэ жилээс эхлэн ГС-ийн санхүүжилтээр ЕБС-иудийн сүрьеэгийн эрт илрүүлэг, үзлэгийг зохион байгуулах шийдвэр гарган эрчимтэй ажиллаж байна. Түүнчлэн ЭМС-ын 2017 оны А306-р тушаалын зааврын дагуу 2018-2020 онд Нийслэлийн ЕБС-иудийн сүрьеэгийн эрт илрүүлэг, үзлэгийг жил бүр зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд

- 2018 онд 23 сургууль дээр 4160 багш, сурагчдыг хамруулан 19 сүрьеэгийн тохиолдлыг олж илрүүлэн эмчилгээнд хамруулсан.
- 2019 оны 5 сарын 16-ны байдлаар нийт 25 сургууль, 1 цэцэрлэгийн нийт 6932 үүнээс 3895 хүүхэд, 3037 багш ажилчдыг хамруулсан Сүрьеэгийн үзлэг оношлогоо хийж нийт 47 сүрьеэ олж илрүүлэн эмчилгээнд хамруулж байна.

Одоо та бүхэндээ зарим Улсын сургуулиудад хийгдэж байгаа үзлэгийн талаарх нарийвчилсан мэдээг танилцуулья. Үүнд:

Нийслэлийн ХУД-ын 15-р сургууль 1974 онд 920 хүүхдийн багтаамжтайгаар байгуулагдсан. Одоогоор нийт 1737 сурагч, 111 багш ажилчидтай байна. 2013 оны 9 сараас 32-р сургуулийн 310 сурагч, 23 багш ажилчид нэмэлтээр ирж сүүлийн жилүүдэд 2-3 ээлжээр хичээллэн нягтрал нь ихэссэн байна. 2017 оноос тус сургуульд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Сүүлийн 3 жилд 4 удаа сүрьеэгийн үзлэг шинжилгээ зохион байгуулж давхардсан тоогоор 5000 гаруй багш, сурагчдыг хамруулсан. 2019 онд Сүрьеэгийн үзлэг, шинжилгээ оношлогоонд нийт багш ажилчдын 95%-ийг хамруулж, сүрьеэгээр өвчилсөн 39 тохиолдлыг илрүүлэн яг одоогоор 20 хүүхдийг эмчилгээнд хамруулж байна. Мөн Сүрьеэгийн далд халдвартай 519 хүүхдийг илрүүлж, 114 хүүхдийг сүрьеэгийн урдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулсан. Одоо 208 хүүхдийг хамруулж байна.

Төв аймгийн Сүмбэр сумын 1-12-р ангийн нийт 288 сурагчид, 37 багш, ажилчидтай сургууль дээр 3 дугаар сарын 25-нд анхны сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн. 5Б ангийн багш өвчтэй байснаар уг илрүүлэг, оношлогоог хийх болсон. Уг оношлогоог хийснээс хойш 2 сурагч сүрьеэ өвчинтэй гарсан. Тус сумаас нийт 32 хүн сүрьеэгийн халдвартай гарсан. Түүнчлэн 162 сурагч урдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдаад явж байна.

Ерөнхийдөө одоогоор эцэг эхчүүд, хүүхдүүдийн зүгээс хүсэлт өгсөн бүх хүүхдүүдийг эмчилгээнд хамруулаад явж байна. Энэ тал дээр ямар нэг асуудал гараагүй байна.

ЗГ-ын 5 сарын 10-ны хурлаар Сүрьеэгийн илрүүлэг, үзлэгийг эрчимжүүлэх асуудлыг сайтар хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг Ерөнхий Сайд өгсөн. Түүнчлэн ЗГ-аас 2020 оны төсөвт 5 ширхэг Дижитал рентген аппарат худалдан авах 750 сая төгрөгийг тусгахаар хэлэлцэн Сангийн Яам, Хууль Зүйн Яамнаас зөвшөөрөгдсөн бөгөөд ЗГ-ын тогтоолын төсөл нь ойрын хугацаанд гарах төлөвтэй байна. Ерөнхийдөө бидний хийж байгаа үйл ажиллагааг ЗГ-ын зүгээс маш сайн дэмжиж ажиллаж байна.

Ц.Пүрэвжав: Сүрьеэгийн асуудлыг зөвхөн ГС-аас санхүүжүүлж байгаа юу? Засгийн Газрын оролцоо энэ тал дээр хэр байгаа вэ?

М.Сэргэлэн: Төсвөөс 1-р эгнээний эмийг 100% санхүүжүүлж байгаа, 2-р эгнээний эмийн хувьд үнэ өртөг өндөртэй бөгөөд одоо хэрэгжиж буй төслийн хүрээнд ЗГ-аас 20%-ийг ГС-аас 80% гаргахаар гэрээ байгуулсан боловч одоогийн байдлаар Глобал Сан 100% нийлүүлэн ажиллаж байна.

Ц.Пүрэвжав: Сүрьеэгийн илрүүлэг, урдчилан сэргийлэх үйл ажиллагаа нийт хүн амын дунд хангалттай хүртээмжтэй бус байгаа байдал ажиглагдаж байна. Т.Энхзаяа даргын хэлсэнээр үзлэг оношлогоо тогтоосон газрууддаа л хийгдэж байна. Ер нь бол урдчилан сэргийлэх, илрүүлэг оношлогоо хийхдээ хүртээмжээ сайжруулах хэрэгтэй санагдаж байна.

М.Сэргэлэн: Тархалтын судалгааны тайланд бүртгэгдэж байгаа сүрьеэгийн тохиолдлоос тархалт даруй 3 дахин их байдаг гэсэн дүгнэлт гарсан. Тиймээс бид 2018 онд 5000 хүн, 2019 онд 6000 хүн, 2020 онд 7000 хүнийг илрүүлэх гэх мэт дандаа дээшээ өгсөх тактикаар ажиллаж байна. 2018 онд энэ зорилтдоо хараахан хүч чадаагүй. Энэ жил хүрэхийн төлөө ажиллаж байгаа бөгөөд цаашдын жилүүдэд 10000 хүнд хүрч ажиллахаар төлөвлөж байна.

П.Анузаяа: Монгол улсын хувьд 2 халдварт өвчний бүх нийтэд хүрэх тусламж үйлчилгээндээ хүрч байгаа гэж дүгнэж байгаа. Мөн ДЭМБ-аас бүх нийтийг хамарсан тусламж үйлчилгээний судалгаагаар 100 000 хүн амд 418 сүрьеэгийн тохиолдол илэрсэн нь бодит байдал үүнээс 3 дахин их байх бололцоотойг харуулсан бөгөөд тооцоогоор жилд 12000 сүрьеэтэй хүнийг илрүүлэх хэрэгтэй гэдгийг харуулж байна.

Ж.Одгарьд: Урьдчилан сэргийлэлтийн талаар ямар мэдээлэл сурталчилгаа явуулж байна вэ?

Т.Энхзаяа: НЭМГ-аас ДОХ/БЗДХ, сүрьеэгийн талаарх асуудалд маш их анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд үр өгөөжтэй, богино хугацаатай 26 контентийг бэлтгэн Глобал Сан, ДЭМБ-ээр дэмжүүлсэн. Одоогоор буюу 2019 онд цацагдах 5 шторк, 4 инфографик олон нийтэд хүрч байгаа бөгөөд Телевизүүдээр цацах секундын төлбөр нь хэт өндөр зардалтай байна. Тиймээс ОУ-ын байгууллагаас энэ талаарх санхүүжилтын дэмжлэгийг хүсэхэд нэр, лого тавиагүй гэх мэт шаардлага их тавьдаг

юм байна. Энэ талаарх үйл ажиллагаанд цаашид Уул уурхайн байгууллагууд дэмжлэг үзүүлэх хүсэлтээ илэрхийлсэн байгаа.

/5 шторкыг нийт гишүүдэд үзүүлж танилцуулав./ Гишүүдийн зүгээс ойлгомжтой хүртээмжтэй байдлыг нь сайшаан цаашид өөрсдийн боломж бололцоогоороо цахим сүлжээгээр олон нийттэй хуваалцах болно гэдгээ мэдэгдлээ. Түүнчлэн сүүлийн үед ТВ гэхээсээ илүү хүмүүсийн амьдралд цахим ертөнц хүчтэй орж байгаа учир түүнийг илүү ашиглаж мэдээлэл түгээх хэрэгтэй. Тиймээс томоохон сайтуудаар мэдээлээ түгээх хэрэгтэй гэдгийг сануулсан.

Энэхүү зар сурталчилгааны ажлыг НЭМҮТ, НЭМГ хамтран 2 долоо хоног бүрт цацаж байгаа бөгөөд өдөрт тус бүр 210000 хүнд цахимаар хуваалцаж байгаа нь том үр дүн билээ.

П.Анузаяа: Одоогоор ДЭМБ-аас 3 шторкыг урд манай байгууллагаас явуулж байсан контентын агуулгатай давхцаж байгаа эсэхийг хянан үзээд БЗДХ, тэмбүү, сүрьеэгийн 1,1 шторкын цацалтанд нийт 11,545 ам.долларын санхүүжилт олгохоор төлөвлөн ажиллаж байна.

Т.Энхзаяа: Гишүүдэд мэдээлэл болгох үүднээс НЭМГ-ын мэргэжилтэн А.Өнөржаргал солигдон БЗДХ, сүрьеэг хариуцсан мэргэжилтнээр н.Амарзаяа болсон тул цаашдын бидний үйл ажиллагаанд ихээхэн нэмэр болно гэдэг найдаж байна.

Мөн Халдварт өвчинтэй тэмцэх, хянах үндэсний хөтөлбөрийн 5 дахь зорилтод БЗДХ/ДОХ-ын талаар авах арга хэмжээг эрчимжүүлэх талаар арга хэмжээ авахдаа

1. Жирэмсэн эмэгтэйн хяналтыг жирэмсний хугацаанд 2 хийдэг байсан бол одоо 3 болгож нэмэгдүүлсэн. Ингэснээр төрөлхийн тэмбүүг хазаарлана гэж харж байна. Түүнчлэн цаашид тэмбүүг устгана гэсэн том зорилттой ажиллаж байна.

Түүнчлэн халдварт өвчний талаарх мэдлэг мэдээллийг сайжруулах зорилгоор

2. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 2018 оноос өмнөх 6 жилд олгодоггүй байсан бөгөөд өнгөрсөн хичээлийн жилээс Эрүүл мэндийн хичээлийг оруулсан нь ихээхэн үр дүнтэй шийдвэр болсон.

Хөтөлбөр 3. ҮЗЗ-ийн 81 дэх удаагийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг батлах талаар Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч танилцууллаа.

ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ ШИЙДВЭР: Сүүлийн үеийн ҮЗЗ-ийн хурлууд маш их олон цагаар үргэлжлэн, сунжирч байгааг харгалзан үзэж зохион байгуулалтыг сайтар төлөвлөн, гишүүдийг чилээлгүй товчхон байдлаар хурлыг хийхийг ҮЗЗ-ийн Ажлын Албанд үүрэг болголоо.

Хөтөлбөр 2-ийн хүрээнд: Өмнөх хурлаар Т.Энхзаяа дарга хэлж байснаараа Хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй төслүүдийн талаарх мэдээллийг хүргэн тусад нь асуудал болгон оруулж ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулах шаардлагатай гэсэг үүрэг өглөө.

Хөтөлбөр 3-ын хүрээнд: зөвхөн ҮЗЗ-ийн дарга сонгоод зогсохгүй, Хяналтын хорооны дарга томилогдоогүй байгаа асуудлыг даруй шийдвэрлэх нь зүйтэй. Учир нь дотоод хяналт бол маш чухал асуудал юм. Түүнчлэн бусад хороодын гишүүдийн идэвхи, оролцоог хянан үзэж шинэчлэн батлах хэрэгтэй. Тиймээс энэ асуудлыг ҮЗЗ-ийн бүтэц зохион байгуулалтын талаар хэлэлцэх гэж оруулья.

Улмаар гишүүд хурлын хөтөлбөрийг хэлэлцэн эцсийн байдлаар дараах байдалтай байхаар хэлэлцэн шийдвэрлэлээ. **Үүнд:**

ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 81 ДЭХ УДААГИЙН ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

Хэзээ: 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 14.00-16.50 цагт

№	Хэлэлцэх асуудал	Шийдвэрийн төсөл	Танилцуулах хүн
1)	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах; ХДХВ/ДОХ-ын түлхүүр хүн амд чиглэсэн 8 орны хамтарсан төслийн талаар мэдээллэх	Хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг танилцуулан батлах; төслийн талаарх цаг үеийн мэдээлэл авах	Б.Мягмар, ҮЗЗ-ийн дарга; Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч; Д.Мягмардорж, ЗЭМ ТББ Б.Сувд, ҮЗЗ-ийн гишүүн
2)	Глобаль Сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүдийн хөдөө орон нутаг дахь хэрэгжилтийн байдлыг танилцуулах <i>Асуулт хариулт</i>	Хэрэгжилтийн байдалтай танилцаж зөвлөж өгөх	Т.Энхзаяа, ҮЗЗ-ийн гишүүн, ЭМЯ-ны НЭМГ дарга
3)	ҮЗЗ ба түүний хороодын бүтэц, зохион байгуулалтыг танилцуулах; Хяналтын хорооны даргыг сонгох; ҮЗЗ-ийн даргын үүрэгт хугацаа дуусгавар болсонг хэлэлцэх	ҮЗЗ-ийн гишүүдийн оролцоо, хороодын бүтцийг танилцуулах; Хорооны даргыг хэлэлцэн батлах; ҮЗЗ-ийн даргыг шинээр сонгон батлах	ҮЗЗ-ийн гишүүд
	Цайны завсарлага		
4)	ҮЗЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын тайлан: <ul style="list-style-type: none"> • Шинэ өөдрөг амьдрал ТББ, Төгс бүсгүйчүүд ТББ, 	Тайланг танилцуулж тулгарсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, заөвлөмж өгөх	ҮЗЗ-ийн гишүүд

	<p>Налайх дүүрэг</p> <ul style="list-style-type: none"> • Төв, Дундговь, Өмнөговь аймгууд • Баянхонгор, Өвөрхангай аймгууд <p><i>Асуулт хариулт</i></p>		
5)	Хяналтын үйл ажиллагаа болон Хянах самбарын талаарх мэдээлэл өгөх, зөвлөмжүүдийг бэлтгэн танилцуулах; 2019-2020 оны ҮЗЗ-ийн хяналтын төлөвлөгөөг танилцуулан хэлэлцэн батлах	Хяналтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах	Хяналтын хорооны гишүүн
6)	Оройн зоог		

Хөтөлбөр 4. ҮЗЗ-ийн санхүүжилтийг хүлээн авахад тулгарч буй асуудал, Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч танилцууллаа.

Б.Оюундарь: 2019 оны 06 сарын 07-ны өдөр ЭМЯ-ны ТНБДарга ҮЗЗ-ийн санхүүжилттэй холбоотойгоор намайг дуудуулан уулзалт зохион байгуулсан бөгөөд тус уулзалтаар ЭМЯ-ны Хуулийн, Санхүүгийн хэлтсийн дарга нар, нягтлан бодогч болон миний бие байлцсан билээ.

Миний хувьд тус уулзалтаар дараах зүйлсийг тэдэнд танилцуулсан. Монгол улсын хувьд 2017-2020 оны хамарсан 3 жилийн санхүүгийн гэрээг 2017 оны 3 дугаар сард ҮЗЗ-ийн дарга, ЭМЯ-ны СХОХ-ийн дарга болон Глобаль Сан хооронд хийсэн. Санхүүгийн жил 3 сарын 31-ний өдрөөр дуусгавар болдогтой холбогдуулан 3 дахь жилийн буюу 2019-2020 оны санхүүжилт 2019 оны 5 сарын 8-ны өдөр Глобаль Сангаас гэрээнд заагдсан байгуулагаруу буюу ЭМЯ-руу 60000 ам.долларыг шилжүүлсэн тухай мэдэгдэл ирсэн (Глобаль Сангаас МУ-ын Сангийн Яамны Төрийн Сангийн дансруу улмаар ЭМЯ-ны Төрийн сангийн дансруу шилжүүлдэг). Ингэхдээ ҮЗЗ-ийн өнгөрөгч оны гүйцэтгэл шалгуур үзүүлэлтэнд хүрч байгаа, ҮЗЗ-ийн ажлын албаны гүйцэтгэл хангалттай байгаа тухай захидал ирсэн.

Тулгамдаж буй асуудал:

ЭМЯ нь ҮЗЗ-тэй ямарваа нэг гэрээ хийгээгүй, үйл ажиллагааг ҮЗЗ баталдаг атлаа санхүүжилтийг ЭМЯ олгодог нь хуульд нийцэхгүй байгаа тул ирээдүйд учирч болох эрсдэлээс сэргийлж цаашид ЭМЯ ҮЗЗ-ийн санхүүжилтийг дамжуулах боломжгүй тухай мэдэгдэж дараах байдлаар асуудлыг зохицуулах тухай санал болголоо. Үүнд:

- ҮЗЗ нь хуулийн этгээдийн гэрчилгээ авч бүртгүүлэн арилжааны банканд данс нээлгэн санхүүжилтээ хүлээн авах (ТББ статустай болох);
- Эсвэл өөр хамтрагч байгуулагуудын дансаар санхүүжилтээ хүлээн авах.

Түүнчлэн энэхүү асуудлыг ҮЗЗ-ийн Гүйцэтгэх хорооны хурлаар 2 удаа, ҮЗЗ-ийн 75 дахь удаагийн хурлаар тус тус хэлэлцүүлж байсан бөгөөд үүнд гишүүдээс гарсан саналыг танилцуулахад:

Хэрэв ҮЗЗ нь ТББ болвол төрийн албан хаагчид энд орж ажиллах нь хуульд нийцэх үү. Дээрээс нь ийм жижиг бүтэцтэй ҮЗЗөвлөл ТББ болох нь ихээхэн төвөгтэй. Тэр үүднээсээ ЭМЯ-ны дансаар авах хэрэгтэй гэсэн саналыг хэлээд тухайн үед шийдвэрлээгүй орхиж байсан. Мөн өөр байгууллагын дансаар санхүүжилт хүлээн авах нь тухайн байгууллагын татварын тайланд нөлөөлдөг тул дэмжигдээгүй тухай мэдээллэсэн юм. Улмаар энэ асуудал энэ жил дахин тулгараад байна.

Би энэхүү асуудалтай холбоотойгоор ТНБДаргад ГС-тай байгуулсан гэрээний сүүлийн буюу 3 дахь жил нь учраас энэ гэрээт хугацаагаа дуусгаад түүний дараа ТББ болох талаар арга хэмжээ авах боломжтой талаараа мэдэгдсэн. Гэтэл энэ арга хэмжээг авахад ирээдүйд учирч болох эрсдэлээс айж байна гэсэн учраас ТББ болоод Арилжааны банкаар санхүүжилт аваад явах яриа болж өндөрлөсөн.

Иймд тухайн тулгарч буй асуудлыг ҮЗЗ-ийн дарга, дэд дарга болон бусад гишүүдэд танилцуулж асуудлыг шийдвэрлүүлэхээр өндөрлөсөн. Тиймээс та бүхэн энэ талаар шийдвэр гаргахад туслалцаа үзүүлнэ үү.

Т.Энхзаяа: ЭМЯ-наас санхүүжилт авч байх хугацаанд танай байгууллагын санхүүжилттэй холбоотой ямар нэг асуудлууд гарч байсан уу?

Б.Оюундарь: Өнгөрөн 2 жилийн хугацаанд ЭМЯ-наас санхүүжилтыг авч байхад жил бүр ЭМЯ-ны санхүүгийн үйл ажиллагаа Үндэсний Аудитын газраар хянагдаад явж байсан. Үүнтэй холбоотойгоор ҮЗЗ-ийн үйл ажиллагаанд ямар нэг асуудал гарсан гэсэн мэдээлэл огт ирж байгаагүй. ҮЗЗ-ийн санхүүжилтийн талаар ямар нэг хатуу хориг тавиагүй. Тиймээс би тухайн уулзалтаар яг ямар хуулийн хэддэх заалтыг зөрчөөд байгаа талаар мэдээлэл хүсэхэд аль ч хэлтсийн дарга надад тодорхой хариулт өгөөгүй. Цаг үе хэцүү болчихсон байгаагаас үүдэн эрсдэлээс айгаад байгаа юм байна гэж би ойлгосон.

Ц.Пүрэвжав: Магадгүй ашиг сонирхлын зөрчил, Төрийн албан хаагчийн ёс зүй гэх мэт зүйлс хөндөгддөг байх. Гэвч энэхүү төслийн ҮХА-ЭМЯ байгаа нөхцөлд бид яах ч арга байхгүй. Санхүүжилт ЭМЯ-ны төрийн сангаар дамжин орж ирж байхад ҮЗЗ-д өөр боломж байхгүй юм шиг санагдаад байх юм. Хэрэв ТББ-аар ҮХА-г сонгосон байсан бол асуудал байхгүй байж болох талтай.

Б.Оюундарь: Танай санхүүжилтыг ЭМЯ гаргах юм бол анхнаасаа гэрээ байгуулж байж хиймээр байна. Ингэхээр бүтцийг нь ЭМЯ баталгаажуулах болно гэсэн.

Өнгөрсөн жилүүдэд санхүүжилттэй холбоотой нилээд их асуудлууд гарч байсан. Миний зүгээс аль болох боломжит хувилбараар нь хувийн дансруугаа хүртэл санхүүжилтыг авч байсан нь би өөрийгөө ч эрсдэлд оруулах магадлалтай байсан. Тэгэхээр цаашид хэн хэнийхээ ажлыг хүндрүүлэхгүйн тулд боломжит зөв хувилбарыг сонгон ажиллах нь зүйтэй санагдсан. Гэвч цаг үе нь 3 жилийн гэрээний 3 дахь жил

таараад байгаа учраас ядаж 3 дахь жилийнхээ гэрээг дуусгах хэрэгтэй санагдаж байна. Энэ гэрээ нь Глобаль Сан, ҮЗЗ-ийн дарга болон тухайн үеийн ЭМЯ-ны Санхүү Эдийн Засгийн Хэлтсийн Дарга н. Пүрэвсүрэн нарын гарын үсэг зурж байсан 3-лсан гэрээ юм. Энэ нь зөвхөн ҮЗЗ-ийн санхүүжилттэй холбоотой байгуулагдсан бөгөөд жилд 60000 ам.доллар хүртэлх санхүүжилт авах гэрээ юм.

Др.Индермохан Нарула: Энэ асуудлыг хуулийн хүрээнд авч үзэхэд 3,5 жилийн өмнө Глобаль Сан болон ЗГ-ыг төлөөлөн Сангийн Яамтай байгуулсан гэрээнд 3 зүйл тусгасан нь

1. Үндсэн Хүлээн Авагч
2. Үндэсний Зохицуулах Зөвлөл
3. Сангийн Орон Нутгийн Агент билээ

Тус гэрээг харвал ҮЗЗ бол ГС-ийн бүрэлдэхүүний нэг хэсэг юм. Эдгээр байгууллагууд үүрэг хариуцлага нь өөр боловч ГС-ийн нэг хэсэг гэдгээрээ л явна. Энийг бид ГС-ийн бүсийн менежер Манаб гэх мэт хэд хэдэн хүмүүстэй 3 жилийн өмнө хэлэлцэж байсан. Энэ гэрээ үйлчилсээр байхад энэ асуудал яагаад дахин дахин гарч ирээд байгаа юм бэ? Миний хувьд тэр гэрээг эргэн харах хэрэгтэй санагдаж байна. ГСан Монгол улсаас гадна олон улс оронтой хамтран ажиллаж байгаа шүү дээ.

М.Сэргэлэн: Энэ талаар нэмэлт тайлбарыг өгье. Монгол улсын Засгийн Газраас Глобаль Сантай хамтын ажиллагааны зарчмын тухай хугацаагүй гэрээг байгуулсан. Энэ үйл ажиллагаанд баримтлах гол бичиг баримт нь ГС-ийн журам юм. Энэхүү журамд дээрх 3 байгууллагын талаар тусгасан байдаг. Тэгэхээр ЭМЯ-ны харьяанд Ажлын албыг байлгавал ҮХА болон ҮЗЗ-ийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг тодруулан ажиллах эсвэл нэгэнт Сангийн Яамтай ГС хамтран ажиллах гэрээ байгуулсан тул энэ талаар судлан албажуулах хэрэгтэй. ТББ болговол сөрөг үр дүн гарч болзошгүй.

Др.Индермохан Нарула: Түүнчлэн би Манабыг юу гэж хэлж байсанг сайн санаж байна. Тэрээр ГС-аас ямар ч ҮЗЗ-ийг ТББ болохыг зөвшөөрөхгүй учир нь тэр нь бие даасан хуулийн этгээд болох бөгөөд ГС-ын бүрэлдэхүүн хэсгээс гарчихна гэж үзэж байсан. Тэрээр энэ асуудлыг хуульчдаас зөвлөмж авч хэд хэдэн удаа хэлэлцсэн.

Т.Энхзаяа: Би энэ талаар асуудал болгож Д.Цогтбаатар даргад танилцуулья. Ажлын албанаас бас нөхцөл байдлыг нарийвчлан Д.Цогтбаатар даргад сайтар танилцуулах хэрэгтэй. Улмаар цаашид дэмжлэг үзүүлэх талаас нь хэлэлцэх болно.

Ц.Пүрэвжав: ТНБД энэ асуудлыг хувь хүний өнцгөөс хараад байна уу. ТНБД энэ төслийн талаар сайн ойлголтгүй байна гэж харж байна. ҮЗЗ сайн ойлгуулах хэрэгтэй.

Ж.Одгарьд: Энэ асуудал байнга яригдаж байдаг тул яаралтай нэг тийш нь болгоод шийдвэрлэх хэрэгтэй. Хөндлөнгөөс харахад энэ асуудал ҮЗЗ-д ихээхэн төвөгтэй байгаа байдал ажиглагддаг. Тиймээс сая М.Сэргэлэн хэлж байсан саналыг нилээд сайн судлах хэрэгтэй санагдаж байна. Би ТББ болохыг нь дэмжье гэсэн саналтай байж байтал

Мохан гуайн мэдээллээр тэр асуудлыг бас болохгүй гэж харлаа. Тиймээс ЭМЯ, СЯ-ны дүрэм журамд нийцсэн Ажлын Албыг байгуулах хэрэгтэй санагдаж байна.

М.Сэргэлэн: Нэг талаас манай Глобал Сангийн үйл ажиллагааны механизмыг хүмүүс тэр бүр сайн ойлгодоггүй. Тиймээс Төрийн байгууллагууд болох ЭМЯ, СЯ-тай хамтран ажиллахад ОУ-ын НҮБ, ДЭМБ-тай хамтран ажиллах хэрэгтэй. Ингэхгүйгээр хэн гарч ирээд юу яриад байгааг төрийн өндөр албан тушаалтнууд ойлгохгүй байх байдал ажиглагддаг. Тиймээс НҮБ-ыг ашиглан зарчим, үйл ажиллагаагаа танилцуулан дэмжлэг үзүүлэхийг хүсэн тал талаас нь оролцох шаардлагатай. Тэгэхгүйгээр Б.Оюундарь ганцаараа явж тайлбарлаад үр дүнд хүрэхгүй байна.

Б.Мягмар: Миний бодлоор М.Сэргэлэнгийн ярьсанг сонсоод Монгол улсад энэ их санхүүжилтыг оруулж ирж байгаа ҮЗЗ-гээ аваад явж чадахгүй байгаа талаар бодоход өрөвдөлтэй, өчүүхэн санагдаж байна. Тэгэхээр тэр хүмүүст энэ талаар ойлгуулах хэрэгтэй. Тэр хүмүүсийн буруу байхгүй өөр байгууллагад ажиллаж байгаад ирсэн шүү дээ. Тиймээс энэ талаарх хууль, дүрэм журмыг нь танилцуулах хэрэгтэй.

Ж.Одгарьд: Энэ асуудлыг шийдүүлсэн салбарын сайдынх нь тушаалыг гаргуулан албан ёсоор дахин энэ асуудал давтагдахааргүй болтол нь шийдвэрлэх хэрэгтэй санагдаж байна. Хугацааг нь төсөл хөтөлбөр хэрэгжиж дуусах хүртэлх байдлаар тавьж өгсөнөөр энэ асуудал ийн дахин дахин үүсэх эрсдэлээс сэргийлэх боломжтой. Ингээд Ажлын Албаны үйл ажиллагааг төвөггүй явуулах хэрэгтэй. Зөндөө олон асуудалтай дээрээс нь энэ мэт асуудлууд үүсч ажил явахгүй байдал гаргамааргүй байна.

Б.Мягмар: Саналыг дэмжиж байна. ҮЗЗ-ийн санхүүжилттэй холбоотой тушаалын төсөл боловсруулаад тэндээ 1,2-р гарын үсгийг зурах хүмүүсийг тодорхойлон зохицуулсан шийдвэр гаргуулья. Улмаар дахин энэ байдлыг давтуулахгүй байх талаас нь ҮЗЗ-ийн санхүүжилтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээн дээр тулгуурлан энэхүү тушаалыг боловсруулан шийдвэр гаргуулья.

Др.Индермохан Нарула: Энэ асуудалтай холбоотой Манабаас ирүүлсэн албаны мэдээллүүдийг нэгтгэн гэрээнүүдийн хамтаар мэдээлэл бэлтгэн хүргүүлэх хэрэгтэй. ОУБ-уудаасаа дэмжлэг авах санал ч бас их үр дүнтэй санагдаж байна.

ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ ШИЙДВЭР: Ямар нэг ТББ байгуулахгүйгээр ҮЗЗ-ийн хурлаас өмнө ҮЗЗ-ийн ажлын албанаас ТНБДаргатай уулзалт товлон тус уулзалтандаа ТЗУГ-ын дарга Д.Цогтбаатар, НЭМГ-ийн дарга Т.Энхзаяа, СОНА-ын багийн ахлагч Индермохан Нарула, ХЗН-ийн мэргэжилтэн М.Сэргэлэн нарыг оролцуулан ДЭМБ, НҮБ гэх мэт ОУБ-ын дэмжлэгийг аван уулзалтыг зохион байгуулахдаа ЭМС-ын тушаалын төслийг боловсруулан хэлэлцэх хэрэгтэй.

ЭМС-ын тушаалын төслийг тус уулзалтаас өмнө М.Сэргэлэнтэй Ажлын Албаны зохицуулагч хамт суугаад сайтар боловсруулж дагалдах ГС-ийн мэдээллүүдийг хамт танилцуулахаар бэлтгэх хэрэгтэй.

Ингэснээр цаашид энэ асуудал дахин гарч ирэх эрсдэлээс сэргийлэх бүрэн боломжтой гэж харж байна.

Б.Мягмар: Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн нийт оролцогчиддоо баярлалаа.

Хурал 14 цаг 10 минутад өндөрлөв.

Хянасан:.....Б.Мягмар, ҮЗЗ-ийн дарга

Боловсруулсан:.....Л.Номин-Эрдэнэ, ҮЗЗ-ийн Ажлын албаны
ажилтан